

АГУУЛГА

Ойлгол, тодорхойлолт

Үүсэл хөгжил, танилцуулга

Бизнес регистрийн санд бүртгэлтэй ААНБ-ийн тоо

Ажиллагсадын тоо

Дотоодын нийт бүтээгдэхүүн

Аймгийн аж үйлдвэрийн салбар

Барилгын салбар

Тээвэр, холбооны салбар

Хүснэгтийн жагсаалт

Дүгнэлт

Ашигласан материал

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Эдийн засгийн идэвхтэй хүн ам: (ажиллах хүч)-д Үндэсний тооцооны системийн хүрээнд, тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна.

Ажиллагч: гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статус хамрагдаж буй иргэнийг ойлгоно.

Бизнес регистр: гэдэг нь аж ахуй нэгж, байгууллагын нэр, хаяг, регистрийн дугаар, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ/ аж ахуй нэгж, байгууллагын борлуулалтын орлого, үндсэн хөрөнгийн хэмжээ/, ажиллагчдын тоо зэрэг үндсэн үзүүлэлтүүдийг агуулсан мэдээллийн сан юм.

Бизнес регистрийн санд: эдийн засгийн бүхий л салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллага болон тэдгээрийн салбар нэгжүүдийн мэдээллийг хамруулна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн: тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нэг жилийн хугацаанд шинээр бий болгосон нийт нэмэгдэл өртгийн хэмжээ юм.

Аж үйлдвэрийн салбар: үйл ажиллагааг аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчид, зардал, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ (биет болон үнийн дүнгээр), борлуулалт, үндсэн хөрөнгө болон санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдээр илэрхийлж, аж ахуйн нэгжийн сар, жилийн тайлан, тооллого, судалгааны үр дүнгээр тоон мэдээллийг ашиглан тэдгээрийг нэгтгэн гаргадаг.

Үйлдвэрлэл: нь тухайн аж ахуйн нэгжийн зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Барилга угсралт их засвар: нь барилга байшин барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан угсрах зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагаа юм.

Ачаа эргэлтийг: тээвэрлэсэн ачааг тээсэн зай /км/-аар үржүүлсэн үржвэрийн нийлбэрээр тооцоно.

Зорчигч эргэлтийг: зорчсон зорчигчдын тоог аялсан зай /км/-аар үржүүлсэн үржвэрийн нийлбэрээр тооцно.

Суурин телефон цэг: гэдэг нь нийтийн телефон сүлжээнд хэрэглэчийн шугамаар телефон станц дээр порт эзлэн зориулалтын төхөөрөмжөөр холбогдсон эцсийн хэрэглэчийг хэлнэ.

Үүрэн утас хэрэглэгч: гэж цахилгаан холбооны нийтийн сүлжээнд хөдөлгөөнт технологийг ашиглан холбогдох боломж бүхий хэрэглэгчдийг ойлгоно.

Утасгүй холбооны хэрэглэгч: гэж тухайн байгуулсан сүлжээний хүрээнд ажиллах радио долгионы холбооны хэрэглэгчийг ойлгоно.

Сансрын холбооны хэрэглэгч: гэж сансрын хиймэл дагуул ашиглан холбогдож буй холбооны хэрэглэгчийг ойлгоно.

БУЛГАН АЙМГИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНГӨ ТӨРХ

Булган аймаг нь Монгол орны төвийн хойд хэсэгт 48,8 мянган ам км буюу Монгол орны нутаг дэвсгэрийн 3.1 хувийг эзлэж, хангайн уулархаг ойт хээрийн бүсэд оршдог.

Нийт талбайн 70.0 хувь нь ХАА-н эдэлбэр газар үүнээс 2.4 хувь тариалангийн газар, 2.3 хувь нь хадлангийн, 58.5 хувь бэлчээрийн, 28.7 хувь ой, 0.5 хувь усан талбай, 2 хувь нь тусгай хэрэгцээний болон нөөцийн газар болно. Хангайн нурууны салбар бэсрэг уулс Хантай, Булган хан, Ханжаргалант, Дулаан хан, Намнан, Хутаг-Өндөр, Онгон сарьдаг, Сардиг Бүтээл, Бөхөн шарын нуруу, Бүрэн хан, Могодын нуруу, Авзага хайрхан, Бүрэгхангай, Дулаан хан, Хөгнө хан, Лах баян, Өрхтэй, Баянзүрх, Баян-Агт зэрэг 2000 метрээс дээш өндөр 20 гаруй уул нуруудтай.

Хамгийн өндөр цэг нь Хантай нурууны оргил Давлан 2171 метр, хамгийн нам дор газар нь Сэлэнгэ мөрний сав Сүмийн Булан, Итгэттолгой орчим далайн түвшнээс дээш 950 метр оршдог. Сэлэнгэ, Эг, Орхон, Туул, Хануй, Хар бух, Тарвагатай, Тарни, Хангал, Ингэт, Хужир, Баян гол, Зэлтэр, Алтайд, Ачуут, Могой, Төлбөр, Балиг, Цагаан гол зэрэг 380 гаруй ариун уст гол горхи, 370 шахам булаг шандтай, Хунт, Хульж, Хануй, Цагаан гол, Чин толгой, Чулуут, Хөөвөр, Зүүн түрүү зэрэг 30 орчим анагаах чадалтай рашаантай.

Харгал, Олон нуур, Цэгээн, Шарга, Айрхан, Хунт, Өрмийн цагаан, Чингийн цагаан, Баяннуур, Галуут зэрэг 71 нууртай. Газар тариаланд тохиромжтой хар ба хар хүрэн бор болон саарал хөрстэй. Хуш, хус, хар мод, улиас, нарс, бургас, хайлаас, яшил, яргай, чаргай зэрэг шилмүүст ба навчит модтой. Төрөл бүрийн жимс жимсгэнэ, эмийн ургамалтай.

Уур амьсгал нь эх газрын, эрс тэс сэрүүвтэр чийглэг, үнэмлэхүй дулаан 34.8 хэм, үнэмлэхүй хүйтэн 44.1 хэм, жилийн дундаж тундас 324 мм боловч зарим жил 500 мм-ээс дээш ч байдаг. Салхины дундаж хурд 2,2 м/сек, цасан бүрхүүлийн дундаж зузаан 15-25 см байдаг. Байгалийн нөөц, ашигт малтмалаас алт, мөнгө, зэс молибден, хар тугалга, чулуун нүүрс, оюу, номин, болор, гантиг боржин чулуу, барилгын төрөл бүрийн эрдэс баялагтай, элс, хайрга, хүрмэн ба шохойн чулуу, зос будаг зэрэг элбэг.

Булган хотод анх 1948 онд хүнсний үйлдвэр, 1951 онд дизель цахилгаан станц, авто тээврийн бааз, 1960 онд барилгын үйлдвэр байгуулагдсан. 1958 онд Монгол Улсын анхны томоохон Гурилын үйлдвэр ашиглтанд орсноор хүнсний анхны томоохон үйлдвэр бий болж, хүнсний үйлдвэрийн эхлэлийг тавьсан түүхтэй. 1965 онд Эрчим хүчний үйлдвэртэй үүдээ нээж, 1980 онд Эрдэнэтээс өндөр хүчдэлийн шугам татсанаар төвийн эрчим хүчний системд холбогдож байнгын тасралтгүй эрчим хүчээр хангагдсан. Анх 1979 онд Эрдэнэт-Булган-Дашинчилэнгийн радио релейны шугам тавигдаж телевизийн тогтмол нэвтрүүлэг үздэг болсон.

Хангал сумын нутагт Зэс молбиден, хүдрийн баялаг орд нээгдэж, түүнийг даган шинэ суурин сүндэрлэсэн нь одоогийн Орхон аймаг бөгөөд 1974 онд Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор Булган аймгийн АДХурлын гүйцэтгэх захиргааны харьяанд Эрдэнэтийн хороо захиргааг байгуулагдан ажиллаж эхэлсэн түүхтэй. Улмаар 1975 оны 12-р сард улсын чанартай биеэ даасан хот байгуулж манай аймгийн нутаг дотор Орхон аймаг төрсөн юм.

Өнөөгийн Булган аймгийн өнгө төрх нь үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын бодлогыг дэмжих, тэргүүний техник технологи, орон нутгийн түүхий эдэд суурилсан жижиг дунд үйлдвэрлэлийг шинээр бий болгоход түлхүү анхаарч аймгийн мал сүргийн бүтцийг зөв зохистой хадгалах, газар зохион байгууллалтын төлөвлөгөөг оновчтой хийх, санхүүгийн зах зээлийг боловсронгуй болгох, татварын бааз суурийг өргөтгөх, улс орны хөгжлийн бодлого зорилттой уялдуулах, авто замын салбарыг хөгжүүлж, улс орон нутгийн замын засвар шинэчлэлийг сайжруулах, цахим засаглал, цахим үйлчилгээг аймгийн хэмжээнд нэвтрүүлэхэд үр дүнтэй ажлуудыг зохион байгуулж хөгжил дэвшлийн төлөө бүх нийтээрээ ажиллаж хөдөлмөрлөж байна.



ХҮН АМ, АЖИЛ ЭРХЛЭЛТ: Булган аймаг нь 2019 оны жилийн эцэст 61344 хүн амтай, үүний 50.7 хувь нь эрэгтэйчүүд, 49.3 хувь нь эмэгтэйчүүд эзэлдэг. Нийт хүн амын 29.1 мянга буюу 47.4 хувь нь эдийн засгийн идэвхтэй хүн ам байгаагийн 28.2 мянган хүн нь ажил хөдөлмөр эрхэлж байна. Булган аймгийн ажиллагсадын тоо өмнөх оноос 3.3 хувиар өсөч, хангайн бүсийн ажиллагсадын 11.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт 1. Эдийн засгийн идэвхитэй хүн ам, бүсээр, мян.хүн

Бүсээр	2015	2016	2017	2018	2019
Хангайн бүс	251.5	274.0	282.7	280.7	260.7
Архангай	41.4	44.8	45.2	46.3	49.9
Баянхонгор	40.5	45.4	43.3	44.7	36.0
Булган	28.3	28.1	30.8	29.5	29.1
Орхон	40.2	44.0	42.1	40.1	35.8
Өвөрхангай	42.9	56.4	59.7	59.0	51.7
Хөвсгөл	58.6	55.0	61.6	61.1	57.4

Хүснэгт 2. Ажиллагсад, бүсээр, мян.хүн

Бүсээр	2015	2016	2017	2018	2019
Хангайн бүс	248.6	249.0	254.8	260.7	239.4
Архангай	40.2	42.5	42.7	43.9	47.5
Баянхонгор	38.9	39.3	40.9	41.5	33.4
Булган	27.0	26.7	27.5	27.3	28.2
Орхон	38.3	37.2	32.2	34.9	31.6
Өвөрхангай	51.4	52.7	55.2	55.9	48.5
Хөвсгөл	52.6	50.4	56.3	57.2	50.2




БИЗНЕС РЕГИСТРИЙН САН: Аймгийн хэмжээнд 2019 онд 1222 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Нийт аж ахуйн нэгж байгууллагын 9372 хангайн бүсэд бүртгэлтэй байгаагийн 13.0 хувь буюу 1222 нь Булган аймагт бүртгэлтэй байна. Аймгийн бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын тоо өмнөх оноос 10.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо

Аймаг	2015	2016	2017	2018	2019	Хангайн бүсэд эзлэх хувь	2019% 2018
Хангайн бүс	7113	7924	8657	8919	9372	100	105.1
Архангай	977	1019	1084	1092	1157	12.3	106.0
Баянхонгор	887	977	1083	1262	1394	14.9	110.5
Булган	984	1071	1186	1202	1222	13.0	101.7
Орхон	1086	2123	2308	2322	1430	15.3	61.6
Өвөрхангай	1371	1196	1348	1326	1737	18.5	131.0
Хөвсгөл	1808	1538	1648	1715	2432	25.9	141.8

Зураг 1. Бизнес регистрийн санд бүртгэлтэй ААНБ-ийн тоо, бүсээр, оноор, өсөлтийн хувь



Аж ахуй нэгж байгууллагыг өмчийн хэлбэрээр нь 8 ангилдаг байна. Үүнээс төрийн өмчийн 132, хувийн 1006, хувийн хамтарсан 2, орон нутгийн өмчийн 46 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 4. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагын тоо, сумаар, өмчийн хэлбэрээр

Аймаг сум	Бүгд	Компани	Хоршоо	Нөхөрлөл	ТӨҮГ, ОНӨҮГ	Төсвийн байгууллага	Төрийн бус байгууллага	Бусад
Булган	1,222.	717	98	85	7	166	146	3
Баян-Агт	47.	30	4	0	0	8	4	1
Бугат	41.	24	4	1	0	6	6	0
Бүрэгхангай	70.	16	2	44	0	6	2	0
Гурванбулаг	32.	15	7	4	0	6	0	0
Дашинчилэн	44.	20	10	3	0	6	5	0
Могод	27.	16	4	0	0	6	1	0
Орхон	45.	29	6	0	0	7	3	0
Сайхан	36.	16	8	1	0	7	4	0
Сэлэнгэ	56.	39	6	1	1	8	1	0
Тэшиг	45.	34	1	1	1	7	1	0
Хангал	85.	59	4	2	2	13	5	0
Хишиг-Өндөр	52.	35	5	1	0	6	5	0
Хутаг-Өндөр	105.	66	7	14	1	10	7	0
Булган	455.	270	21	8	2	57	95	2
Баяннуур	34.	20	3	4	0	6	1	0
Рашаант	48.	28	6	1	0	7	6	0

Хүснэгт 5. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагын тоо, сумаар

Засаг захиргааны нэгж	Бүгд	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	Уул уурхай, олборлолт	Боловсруулах үйлдвэрлэл	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа
Бүгд	1,222.	188.	45.	83.	5.	3.
Баян-Агт	47.	1.		4.		
Баяннуур	34.	6.				
Бугат	41.	8.		6.		
Булган	455.	32.	5.	33.	3.	
Бүрэгхангай	70.	7.	37.	3.		
Гурванбулаг	32.	4.		1.		
Дашинчилэн	44.	8.		1.		
Могод	27.	0.				
Орхон	45.	9.		5.		
Рашаант	48.	6.				
Сайхан	36.	4.	2.	2.		
Сэлэнгэ	56.	27.		4.		
Тэшиг	45.	11.		2.	1.	1.
Хангал	85.	19.		14.	1.	
Хишиг-Өндөр	52.	6.	1.	3.		
Хутаг-Өндөр	105.	40.		5.		2.

Хүснэгт 5-ын үргэлжлэл

Засаг захиргааны нэгж	Барилга	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	Мэдээлэл, холбоо	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	Урлаг, үзвэр, тоглоом наадам
Бүгд	33.	347.	12.	41.	16.	25.	31.
Баян-Агт		17.		2.	1.		2.
Баяннуур		17.		2.			1.
Бугат		6.		2.			1.
Булган	30.	119.	6.	14.	14.	18.	10.
Бүрэгхангай		5.					1.
Гурванбулаг		13.				2.	1.
Дашинчилэн		15.		1.	1.	2.	1.
Могод		14.		2.			1.
Орхон		9.		2.			1.
Рашаант	1.	17.		5.		1.	2.
Сайхан		14.	1.				2.
Сэлэнгэ	1.	10.	2.				2.
Тэшиг		15.	1.	3.			1.
Хангал		25.	1.	3.		1.	3.
Хишиг-Өндөр		24.	1.	2.			1.
Хутаг-Өндөр	1.	27.		3.		1.	1.

Хүснэгт 5-ын үргэлжлэл

Засаг захиргааны нэгж	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Боловсрол	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа
Бүгд	1.	72.	30.	55.	76.	44.	115.
Баян-Агт		4.	5.	3.	2.	3.	3.
Баяннуур		2.		2.	2.	1.	1.
Бугат		3.	4.	2.	3.	1.	5.
Булган	1.	15.	7.	23.	36.	16.	73.
Бүрэгхангай		10.		2.	3.	2.	
Гурванбулаг		5.	1.	2.	2.	1.	
Дашинчилэн		3.	1.	2.	2.	2.	5.
Могод		3.		2.	2.	2.	1.
Орхон		7.	2.	2.	3.	1.	4.
Рашаант		2.	3.	2.	2.	1.	6.
Сайхан		2.		2.	3.	2.	2.
Сэлэнгэ		2.		2.	2.	3.	1.
Тэшиг		2.	1.	2.	2.	2.	1.
Хангал		3.	1.	3.	6.	2.	3.
Хишиг-Өндөр		4.	1.	2.	2.	1.	4.
Хутаг-Өндөр		5.	4.	2.	4.	4.	6.



ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН: Урьдчилсан гүйцэтгэлээр 2019 онд Булган аймаг нь 365.8 тэрбум төгрөгийн ДНБ-н бий болгосны 53.4 хувийг хөдөө аж ахуйн салбар, 21.9 хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 24.8 хувийг үйлчилгээний салбар бүрдүүлсэн байна. 2019 онд урьдчилсан гүйцэтгэлээр Булган аймаг нь хангайн бүсийн ДНБ-ний 7.6 хувь буюу 365.8 тэрбум төгрөгийг бүрдүүлж өмнөх оноос 37.2 сая төгрөг буюу 12.9 хувиар өссөн байна. Нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ 6.0 сая төгрөг болсон нь өмнөх оноос 13.2 хувиар өсчээ. Хангайн бүсийн аймгуудын ДНБ-ний 45 хувийг Орхон аймаг бүрдүүлсэн байна. Мөн хангайн бүсийн аймгуудын ДНБ-ний 27.9 хувийг хөдөө аж ахуйн салбарт, 52.5 хувийг аж үйлдвэр, барилгын салбарт, 19.6 хувийг үйлчилгээний салбар бий болсон нэмүү өртөг эзэлж байна.

Хүснэгт 6. Дотоодын нийт бүтээгдэхүүн, бүсээр, оны үнээр, сая.төг

Аймаг	2012				2013				2014			
	ДНБ, сая.төг	Дүнд эзлэх хувь			ДНБ, сая.төг	Дүнд эзлэх хувь			ДНБ, сая.төг	Дүнд эзлэх хувь		
		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ
Хангайн бүс	2269030.4	27.8	51.4	20.8	2701639.2	32.0	47.3	20.7	3 080 305.9	32.5	44.6	22.9
Архангай	252448.9	60.7	13.3	25.9	315 937.6	63.2	15.2	21.5	367 617.3	64.1	13.0	22.9
Баянхонгор	193811.7	53.2	11.4	35.4	261 220.3	55.8	12.3	31.9	328 787.0	51.5	16.6	31.9
Булган	188164.5	62.9	15.6	21.5	257 336.7	63.7	17.6	18.6	293 916.2	62.8	15.9	21.4
Орхон	1138014.6	1.0	88.4	10.6	1 190352.1	1.3	86.7	12.1	1 266 273.7	1.1	84.3	14.6
Өвөрхангай	206878.9	48.1	12.3	39.6	307 253.1	53.1	14.9	32.0	382 265.6	51.7	15.7	32.5
Хөвсгөл	289711.7	50.2	16.9	32.9	369539.4	48.1	20.0	31.9	441 446.1	45.5	22.0	32.5

Хүснэгт 6 үргэлжлэл

Аймаг	2015				2016*				2017			
	ДНБ, сая.төг	Дүнд эзлэх хувь			ДНБ, сая.төг	Дүнд эзлэх хувь			ДНБ, сая.төг	Дүнд эзлэх хувь		
		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ
Хангайн бүс	3 246 405.4	32.9	44.3	22.8	3121955.0	30.8	45.2	24.0	3828834.8	26.1	54.6	19.3
Архангай	393 776.8	63.9	13.6	22.5	381718.4	61.1	14.4	24.5	410709.0	59.1	17.9	23.0
Баянхонгор	349 375.7	51.7	17.4	30.9	353492.8	45.1	23.7	31.2	379745.6	46.6	24.0	29.4
Булган	307 915.0	61.5	16.8	21.8	294493.2	57.3	18.9	23.8	280807.7	50.9	23.5	25.7
Орхон	1 315 632.9	1.1	83.9	15.0	1204146.7	1.0	83.4	15.5	1822171.1	0.6	89.3	10.1
Өвөрхангай	407 747.2	52.4	16.1	31.5	402322.0	47.2	19.0	33.8	436087.0	50.7	20.6	28.7
Хөвсгөл	471 957.9	46.2	21.8	32	485781.8	41.0	27.8	31.2	499314.4	41.4	28.6	30.0

Хүснэгт 6 үргэлжлэл


Аймаг	2018				2019**			
	ДНБ, сая.төг	Дүнд эзлэх хувь			ДНБ, сая.төг	Дүнд эзлэх хувь		
		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ		Хөдөө аж ахуй	Аж үйлдвэр, барилга	Үйлчилгээ
Хангайн бүс	4 158 462,3	25,8	54,0	20,3	4 805 749,6	27,9	52,5	19,6
Архангай	431 367,3	55,1	20,8	24,1	556 790,0	59,5	18,7	21,8
Баянхонгор	417 659,1	44,3	25,9	29,9	476 761,7	45,0	26,2	28,8
Булган	318 533,9	51,2	24,0	24,8	365 829,7	53,4	21,9	24,8
Орхон	1 871 485,7	0,7	88,3	11,0	2 080 088,6	0,8	88,3	10,9
Өвөрхангай	502 110,6	43,1	25,5	31,4	606 108,5	44,0	26,9	29,0
Хөвсгөл	617 305,8	41,7	30,5	27,9	720 171,2	43,8	29,8	26,4

** - урьдчилсан гүйцэтгэл

Зураг 2. Дотоодын нийт бүтээгдэхүүн тэр бум төгрөг



Зураг 3. Аймагын дотоодын нийт бүтээгдэхүүн, салбараар, хувиар, оноор






АЖ ҮЙЛДВЭР: Аймгийн аж үйлдвэрийн газрууд 2019 онд 7081.3 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 1.1 хувиар өссөн байна. Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 79.2 хувийг боловсруулах салбар, 20.8 хувийг цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэр бий болгож байна. 2019 онд уул уурхайн салбарт үйлдвэрлэлт хийгдээгүй болно. Үйлдвэрт нуранг үүсч үйл ажиллагаа явуулахад хүндрэл гарч үйл ажиллагаа зогссон.

Хүснэгт 7. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, оны үнээр, салбараар, сая.төг

Салбараар	2018	2019	$\frac{2019}{2018} \%$
Нийт дүн	7000.5	7081.3	101.2
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	565.3	0.0	0.0
Нүүрс олборлолт	565.3	0	0.0
Боловсруулах аж үйлдвэр	4919.8	5611.7	114.1
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	4828.5	4806.7	99.5
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	3205.1	3132.8	97.7
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	92.8	67.5	72.7
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	1011.5	938.0	92.7
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	518.9	668.3	128.8
Нэхмэлийн үйлдвэрлэл	33.3	99.5	298.8
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	11.4	8.5	74.6
Мод, модон эдлэл	46.4	27.4	59.1
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	0.0	648.5	-
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	0.0	20.8	-
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	1515.3	1469.6	97.0

Зураг 4. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, оноор, сая.төг



Зураг 5. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлт, оноор

Дулааны эрчим хүч

2018
19.5 мян.Гкал



2019
39.9 мян.Гкал

Түгээсэн цэвэр ус

2018
28.0 мян.м3



2019
47.5 мян.м3

Гурил үйлдвэрлэл

2018
1019.8



2019
855.6 тн

Мах, махан бүтээгдэхүүн

2018
441.6 тн



2019
435.2 тн

Гурилан бүтээгдэхүүн

2018
53.8 тн



2019
45.1 тн

2018
3.7 тн



2019
5.5 тн

2018
11.0 тн



2019
9.1 тн

Савалсан айраг

2018
26.6 мян.л



2019
17.7 мян.л

Бог будаа

2018
1.9 тн



2019
5.1 тн

Аймгийн аж үйлдвэрийн газрууд 2019 онд 9184.3 сая төгрөгийн борлуулалт нийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.4 хувиар буурсан байна. Бүтээгдэхүүн борлуулалт буурсан шалтгаан нь гурилын үйлдвэрүүдийн гурил борлуулалт буурсан, үлдэгдэл бүтээгдэхүүн ихтэй байна

Хүснэгт 8. Аж үйлдвэрийн салбарын борлуулалт, оны үнээр, оноор, сая.төгрөг

Аж үйлдвэрийн салбар	2018	2019	$\frac{2019}{2018} \%$
Нийт дүн	9512.2	9184.3	96.6
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	508.7	-	-
Нүүрс олборлолт	508.7	-	-
Боловсруулах аж үйлдвэр	4997.5	5043.3	100.9
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	4898.1	4182.6	85.4
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	3246.5	2226.2	68.6
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	94.2	60.9	64.6
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	828.3	977.7	118.0
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	728.9	917.7	125.9
Нэхмэлийн үйлдвэрлэл	39.7	152.4	383.9
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	13.1	11.4	87.0
Мод, модон эдлэл	46.4	23.6	50.9
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	-	647.7	-
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	-	25.4	-
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	4006	4141	103.4


Зураг 6. Аж үйлдвэрийн салбарын борлуулалт, боловсруулах салбарын борлуулалтын эзлэх хувь, оноор, сая.төг






БАРИЛГА: Барилга угсралт, их засварын ажил 2019 онд 30530.9 сая төгрөгийн ажил гүйцэтгэсэн нь өмнөх оны мөн үеэс 21655.4 сая.төг буюу 3.4 дахин өссөн байна. Нийт барилга угсралт их засварын ажлын 63.8 хувийг хатуу хучилттай авто зам, 7 хувийг инженерийн барилга байгууламж их засварын ажил, 7 хувийг сургууль, 6 хувийг эмнэлэг тус тус эзэлж байна. Хатуу хучилттай авто замын ажил 1257 хувь, сургууль 244 хувь, инженерийн барилга байгууламжийн ажил 182.3 хувь, орон сууцны барилга байгууламжийн ажил 120.7 хувиар тус тус өссөн бол орон сууцны бус барилгын их засвар 48.1 хувь, орон сууцны барилга, үйлчилгээтэй 82 хувь, худалдаа үйлчилгээний барилгын ажил 87 хувиар тус тус буурсан байна.

Зураг 7. Барилга угсралт, их засварын ажил



Зураг 8. Барилга угсралт, их засварын ажил, улирлаар



Хүснэгт 9. Барилга угсралт, их засварын ажил, төрлөөр, сая.төгрөг

Барилгын төрөл	2014	2015	2016	2017	2018	2019
	сая.төг					
Нийт	12 234.8	14 644.9	15 063.8	20 904.5	8 875.5	30530.9
Орон сууцны барилга	5 695.0	2 675.0	2 780.0	95.0	700.0	965.0
Орон сууцны бус барилга	2 359.3	7 674.4	6 124.7	9 872.8	3 184.5	120.0
Үйлдвэрийн	30.0		112.1			
Худалдаа, үйлчилгээний	844.0	205.5	351.0	2.0	1 410.0	50.0
Эмнэлэгийн	845.0	434.				1828.9
Сургууль, соёлын	85.0	5 002.3	4 961.5	6 806.1	860.0	2653.1
Бусад	555.3	2 032.6	700.1	3 064.8	914.5	2346.0
Инженерийн барилга, байгууламж	1 141.1	3 327.6	4 366.7	9 126.1	2 530.5	20305.9
Эрчим хүчний			689.9		446.1	
Авто зам	146.4			806.0	1 550.0	19599.0
Гүүр, гүүрэн гарц	183.6	1 693.6	2 700.0	6 832.0		
Далан, суваг, шугам, сүлжээ	70.3	1 598.8	517.2	1 141.3		87.7
Бусад (зам, талбайн бусад ажил)	740.7	35.1	459.7	346.7	534.5	619.2
Их засварын ажил	3 039.4	968.0	1 792.5	1 810.6	2 460.5	2261.4

Хүснэгт 10. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, гүйцэтгэгчийн төрлөөр, сая.төг

нэгж	2018-I	2018-II	2018-III	2018-IV	2018	2019-I	2019-II	2019-III	2019-IV	2019
Нийт	85.4	3,802.1	1,969.5	2,018.4	7,875.4	1,436.0	2,897.9	3,788.6	2,919.4	11,041.9
Булган	85.4	2,777.6	1,969.5	1,981.2	6,813.7	1,338.0	1,219.7	833.3	1,946.9	5,337.9
Баян-Агт		110.0			110.0					
Баяннуур								150.0		150.0
Бугат							980.0	910.0	210.0	2,100.0
Бүрэгхангай							298.7	693.2	126.2	1,118.1
Могод							247.5	495.0	82.5	825.0
Орхон							110.0			110.0
Рашаант						98.0	42.0	638.0	553.8	1,331.8
Сэлэнгэ		914.5			914.5					
Хишиг-Өндөр								69.0		69.0
Хутаг-Өндөр				37.3	37.3					




ТЭЭВЭР. Аймгийн тээврийн салбар нь 2019 онд 4.5 мянган тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 31.0 хувиар буурсан, ачаа эргэлт 1016.6 мян.тн.км байгаа нь 1.6 дахин өссөн байна. Тус салбар нь 2019 онд 42.5 мянган хүн тээвэрлэсэн нь өмнөх оноос 33.6 хувиар өссөн байна.

Тээврийн салбарын нийт орлого оны үнээр 63.4 сая төгрөгт хүрч өмнөх оноос 9.3 дахин өссөн байна.

Хүснэгт 11. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлт

Тээврийн төрөл	2015	2016	2017	2018	2019
Тээврийн салбарын нийт орлого, мян.төг	48358.8	38297	32781.5	57446.9	63364.8
Ачаа эргэлт мян.тн.км	479.9	4747.4	1982.5	1000.1	1016.6
Тээсэн ачаа, мян.тн	9.6	10.3	9.2	14.5	4.5
Зорчигч эргэлт, мян.хүн.км	17135.1	5855.1	2362.8	11715.1	11216.4
Зорчигчдын тоо, мян.хүн	33.4	33.5	35.4	31.8	42.5

Зураг 9. Тээврийн нийт орлого, оноор, мян.төг



Хүснэгт 12. Тээврийн хэрэгслийн тоо, төрлөөр, оноор

Төрөл	2014	2015	2016	2017	2018	2019
Авто машины төрлөөр	8274	8879	9146	9475	9486	10077
суудлын	3447	3829	4058	4489	4696	5068
ачааны	3437	3787	3936	3989	3895	4133
автобус	291	317	279	263	190	164
тусгай зориулалтын	60	65	85	154	150	157
бусад /мотоцикл, механизм, чиргүүл/	1039	881	788	580	555	555
Ашигласан хугацаагаар						
3 жил хүртэл		136	190	216	332	632
4-9 жил	1122	916	880	784	742	1053
10 ба түүнээс дээш	7152	7826	8076	8475	8412	8392

Хүснэгт 13. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан авто машины тоо, сумаар

Сум	2019	Үүнээс								
		төрлөөр						Ашигласан хугацаагаар		
		суудлын	ачааны	автобус	тусгай зориулалтын, бусад	чиргүүл	мотоцикл	3 жил хүртэл up to 3 year	4-9 жил -9 year	10 ба түүнээс дээш
Бүгд	10077	5068	4133	164	157	79	476	632	1053	8392
Булган	2118	1435	456	27	27	22	151	74	296	1748
Баян-Агт	412	150	222	7	1	2	30	45	30	337
Баяннуур	264	124	102	2	20	12	4	24	17	223
Бугат	310	101	143	10	4	1	51	35	45	230
Бүрэгхангай	577	271	244	6	38	6	12	35	63	479
Гурван булаг	544	227	292	20	3	0	2	20	32	492
Дашинчилэн	554	279	249	14	6	0	6	13	31	510
Могод	510	207	289	4	4	4	2	28	56	426
Орхон	547	197	272	8	14	3	53	67	74	406
Рашаант	482	221	233	12	10	4	2	9	26	447
Сайхан	623	275	315	7	2	3	21	48	59	516
Сэлэнгэ	428	176	228	5	4	1	14	31	36	361
Тэшиг	418	299	100	4	1	7	7	33	50	335
Хангал	478	220	216	7	2	0	33	82	95	301
Хишиг-өндөр	561	274	240	17	8	6	16	30	46	485
Хутаг-Өндөр	825	427	352	7	1	4	34	37	58	730
Хялганат	426	185	180	7	12	4	38	21	39	366


ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ:

Холбооны салбарын орлого 534.7 сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.7 хувиар өссөн байна. Телефон цэгийн тоо 2019 оны эцэст 548 болж өмнөх оноос 2.4 хувиар өсч, интернет хэрэглэгчдийн тоо 49957 болж өссөн нь үүрэн операторт ухаалаг утас ашиглан (4-G) систем ашиглагчдын тоо өссөн мөн Univision шинээр орж ирсэн нь голлон нөлөөлж байна.

Хүснэгт 14. Холбооны салбарын үзүүлэлт, оноор

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018	2019
Харилцаа холбооны үйлчилгээний орлого, сая.төг	378.3	503.9	511.9	522.8	498.7	534.7
Хүн амаас орсон орлого, сая.төг	89.8	248.9	239.2	202.4	210.8	48.2
Суурин утасны цэг, тоо	1025	930	752	613	561	548
1000 хүнд ногдох суурин утасны цэг	1.7	1.5	1.2	1	1	1
Кабелийн телевиз хэрэглэгчид	1507	1631	1713	1643	1013	1352
Үүрэн утас хэрэглэгчдийн тоо (давхардсан тоогоор), мян. хүн* ¹	35.4	35.5	35.6	36.1	39.4	65.7
Утасгүй холбооны хэрэглэгчид**	-	-	-	-	-	-
Шугамын радио цэг, мян.ш	-	-	-	-	-	-
Интэрнэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага*	10	10	10	10	10	10
Интэрнэт кафе*	10	10	10	10	10	10
Интэрнэтийн байнгын хэрэглэгчид, мян.хүн	8.7	3.9	7.2	4.7	2.3	49.9

Зураг 10. Суурин телефон цэг, үүрэн телефон хэрэглэгчид, оноор



■ суурин утасны цэг, мян ■ үүрэн утас хэрэглэгчдийн тоо (давхардсан тоогоор), мян.хүн

ДҮГНЭЛТ

Аймгийн аж үйлдвэрийн салбарын хөгжил удаан байгаа хэдий ч аймгаас гаргасан бодлого зорилтод тулгуурлан хөгжлийн чиглэлийг тогтоож, нэгдсэн бодлогоор дэмжиж байгаагийн үр дүнд дэд бүтэц, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа нь ажиглагдаж байна. Цаашид хөдөө аж ахуйд түшиглэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, судлагдсан орд газар, олон жилийн нөөцтэй Сайхан сумын нүүрсний уурхай, Бүрэгхангай сумын төмрийн хүдрийн орд, Орхон сумын Мааньтын шохойн ордыг зөв менежментээр байгаль орчинд ээлтэй бодлогоор дэмжих, ард иргэдээ экологийн аюулгүй бүтээгдэхүүнээр хангах бодлогыг барьж ажиллахад онцгой анхаарах шаардлага байна.

2019 онд урьдчилсан гүйцэтгэлээр Булган аймаг нь хангайн бүсийн ДНБ-ний 7.6 хувь буюу 365.8 тэрбум төгрөгийг бүрдүүлж өмнөх оноос 37.2 сая төгрөг буюу 12.9 хувиар өссөн. Мөн хөнгөн хүнсний чиглэлээр жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлыг бодлогоор дэмжиж аймгийнхаа иргэдийг талх, нарийн боов, гурил, гурилан бүтээгдэхүүнээр бүрэн хангах төдийгүй хөрш зэргэлдээ аймаг, хотын зах зээлд нийлүүлэх боломж байна. Нийт барилга угсралт их засварын ажлын 63.8 хувийг хатуу хучилттай авто зам, 7 хувийг инженерийн барилга байгууламж их засварын ажил, 7 хувийг сургууль, 6 хувийг эмнэлэг тус тус эзэлж байна.

Интернет хэрэглэгчдийн тоо 49957 болж өссөн нь үүрэн операторт ухаалаг утас ашиглан (4-G) систем ашиглагчдын тоо өссөн мөн Univision шинээр орж ирсэн нь голлон нөлөөлж байна. Энэхүү танилцуулгаас дүгнэлт хийхэд аж үйлдвэр, барилга үйлчилгээний салбарын үйл ажиллагаа нь хүн амын хэрэглээ, дэд бүтэц болон ашигт малтмалын нөөц, уул уурхайн газар зүйн байрлалаас илүү хамааралтайг харуулж байгаа бөгөөд тухайлбал боловсруулах аж үйлдвэрийн салбар нь хүн амынхаа хэрэгцээг бүрэн хангахад оршино. Манай аймгийн хувьд хөдөө аж ахуй, уул уурхай хосолсон бүс нутаг төдийгүй цаг уурын таатай нөхцөлтэй, зам харилцаа хөгжсөн, дэд бүтэц эрчимтэй хөгжиж байгаа Орхон, Хөвсгөл, Сэлэнгэ аймгуудтай хил залгаа оршдог олон давуу талууд байна.

Танилцуулгын зорилго нь Булган аймгийн дэд бүтцийн салбарын өнөөгийн байдлыг харуулсан бөгөөд цаашид бодлого боловсруулагч танилцуулгатай танилцан аж үйлдвэрийн салбарт зайлшгүй шаардлагатай байгаа хүчин зүйлийг судалж, зөв бодлого хэрэгжүүлэн ажиллана гэдэгт итгэлтэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол улсын Статистикийн эмхтгэл 2019 он
2. Булган аймгийн Нийгэм эдийн засгийн жил бүрийн танилцуулга
3. www1212.mn вэб сайт
4. Ажиллах хүчний судалгааны улирлын танилцуулга 2018 он

Статистикийн мэдээллийг хэрхэн авах вэ?

www.1212.mn Статистикийн мэдээллийн нэгдсэн сан



Ухаалаг гар утас, таблет ашиглан статистикийн мэдээлэл авах ezStat аппликейшн



Статистикийн хэвлэл бүтээгдэхүүнийг унших Монстат аппликейшн



www.nso.mn сайтад бүртгүүлснээр цахим шуудангаар тогтмол авч болно. (bulgan.nso.mn)



[www.facebook.com/pages/ Статистик-Мэдээлэл](https://www.facebook.com/pages/Статистик-Мэдээлэл)

www.twitter.com/statistic_mn



1900-1212

70342766

1 минут= 200 төгрөг

ТЭМДЭГЛЭЛ

Танилцуулгыг хянасан:

Хэлтсийн дарга

М.Мөнхбат

Танилцуулгыг бэлтгэсэн:

Ахлах мэргэжилтэн

А.Нарантуяа

Мэргэжилтэн

Г.Надин

Ж.Мөнхзул